



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 31

Эрдэнэт

2017 онд ойгоос бэлтгэх модны
хэмжээ батлах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2016 оны А/111 дүгээр тушаалыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Аймгийн Ойн сангийн төлөв байдал, ойн нөөцийг харгалзан 2017 онд Жаргалант сумын ойн сангаас ойн цэвэрлэгээгээр бэлтгэх хэрэглээний шинэс модны дээд хэмжээг 100 шоометр, түлээний шинэс модны дээд хэмжээг 2000 шоометрээр тус тус тогтоосугай.

2.Холбогдох хууль, журмын дагуу ойгоос бэлтгэх модны төрөл, тоо хэмжээг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр тогтоохыг Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвшөөрсүгэй.

3.Баян-Өндөр сумын иргэдийн түлшний модны хэрэгцээг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2016 оны А/111 дүгээр тушаалын 3 дахь заалтын дагуу ойн цэвэрлэгээ хөтөлбөр хэрэгжиж байгаа аймагтай харилцан тохиролцож, түлээний модоор хангах асуудлыг шийдвэрлэхийг аймгийн Засаг дарга Д.Батлутад үүрэг болгосугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА